

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2022 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргаас 6 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулан, 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Мал аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын Засгийн газрын 2022 оны 277 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 09 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын албан даалгаварын хүрээнд нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “НЭГ ӨРХ-НЭГ АЖЛЫН БАЙР” арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хамтран 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр “АЖИЛ ХИЙХ ГОЁ” хөдөлмөрийн өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгт Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын “Нэг өрх-нэг ажлын байр” арга хэмжээнд хамрагдсан өрхийн төлөөлөл болон ажил хайгч иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа авдаг өрхийн нийт 150 гаруй иргэд хамрагдлаа.

2022 оны 09 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд “Говийн бүсийн чуулга харваа-2022” зохион байгуулагдсан. Тус тэмцээнд Өмнөговь, Дорноговь, Дундговь, Баянхонгор, Говьсүмбэр 5 аймгийн 10 багийн Улсын цолтой-8, Аймгийн цолтой-55, Спортын мастер-31, Дэд мастер-13, Сумын цолтой-29, 1, 2, 3-р зэргийн 14 нийт 146 харваач оролцсон.

2022 оны 09 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд “Боржигин тойром -2022” шагайн харвааны тэмцээн зохион байгуулагдсан.

Монгол улсын Засгийн газар, Польш улсын Засгийн газрын хамтын ажиллагааны хүрээнд аймгийн төвд цэвэрлэх байгууламж барих ажлыг эхлүүлэхээр 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр шав тавих арга хэмжээг зохион байгууллаа.

Монгол Улсын аварга П.Бүрэнтөгсийн санаачилгаар “Бүрэн Монгол” төслийн арга хэмжээ Говьсүмбэр аймагт 2022 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулагдаж, 1 залуу гэр бүлд 6 ханатай, иж бүрэн тавилгатай гэр олгосон.

Батлан хамгаалах яам, аймгийн Засаг даргын Тамгын газраас хамтран Говийн бүсийн аймгуудын “Цэргийн бэлтгэл” сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 14-17-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Орон нутагт нэн шаардлагатай, эрэлттэй мэргэжлээр суралцаж буй оюутнуудад “Аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг” олгох үйл ажиллагааг 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн. 2021 онд уг тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан 4 оюутан их, дээд сургуулиа амжилттай төгсөн, орон нутагтаа ирж ажиллаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэгт хамрагдахаар 17 оюутан материал ирүүлснээс болзол шаардлагыг бүрэн хангасан 10 оюутанг шалгаруулан, сургалтын төлбөрт тус бүр 2.0 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор шийдвэрлэж, төгссөний дараа орон нутагтаа ажиллахаар гэрээ байгуулсан.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллаж байна.

2022 оны 09 дүгээр сарын татварын орлогын төлөвлөгөө 7,735,262.8 мян.төгрөг байгаагаас гүйцэтгэл 7,206,016.3 мян.төгрөг буюу 93.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогын төлөвлөгөө 1,344,901.0 мян.төг, хүлээгдэж буй гүйцэтгэлээр

2,063,968.0 мян. төгрөг буюу 100 хувь, аймгийн төсвийн орлого 1,174,187.0 мян.төгрөг буюу 69.6 хувь, сумдын төсвийн орлого 3,968,008.0 мян.төгрөг буюу 84.5 хувийн тус тус гүйцэтгэлтэй байна.

Аймгийн хэмжээнд татвар төлөгч хуулийн этгээдийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байгаа бөгөөд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр 642 хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байсан бол 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 692 болж өссөн байна. Үүнд: ХК-1, ХХК-358, ББН-5, ЗБН-9, Хоршоо-29, ХЗХоршоо-1, ОНӨҮГ-6, Салбар-66, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ-217 бүртгэлтэй байна.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр: Аймгийн хэмжээнд нийт төсвийн болон орон нутгийн өмчит 75 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. 2022 оны 08 сарын 30-ны байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилт 94.4 хувьтай байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас 9 дүгээр сард Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг, Илчлэг шивээ ОНӨААТҮГазар, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, Шивээговь сумын ОНХСангийн үйл ажиллагаанд тус тус хяналт шалгалт хийсэн.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төрийн архив: Архивийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд хөмрөг-2, хадгаламжийн нэгж-11, заалт -5158, хүний нэр- 1958, байгууллагын нэр- 521, газарзүйн нэр- 1653, холболт- 739, хуудас-518 баримтыг программд холбож ажилласан. Архивын тасгаас 2022 оны 09 дүгээр сард 11 иргэнд лавлагаа хуулбар гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

Улсын бүртгэл: “Цахим үндэстэн” хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд 10523 иргэнд тоон гарын үсэг олгохоос 2500 иргэнд олгож, иргэдэд тоон гарын үсэг олгох үйл ажиллагаа 22.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 2022 оны 09 дүгээр сард дараах чиглэлээр нийт 1280 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 25
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 24
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 26
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 13
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн -50
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо –25
- Тоон гарын үсэг олголт- 602

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 4
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 33
- Гэрээний бүртгэл - 57
- Барьцааны гэрээний бүртгэл - 131
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 5

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 3
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 13

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 2
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 25
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар – 240

Хууль сахиулах чиглэлээр: Аймгийн цагдаагийн хэлтэст 2022 оны 09 дүгээр сард 91 гомдол мэдээлэл ирсэнээс гэмт хэргийн 30, зөрчлийн 61 хэрэг нээж шалгасан. Мөн зөрчил үйлдсэн 15

иргэнийг 2,750,000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 31 иргэнийг эрүүлжүүлж, 16 иргэнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 33 иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, эргүүл, шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж, 9 дүгээр сард 56 санамж, анхааруулга, зөвлөмж, 27 видео шторк, бусад 10, нийт 93 сургалт, сурталчилгааны мэдээ, мэдээллийг цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр иргэдэд хүргэн ажилласан бөгөөд давхардсан тоогоор 172 алба хаагч гудамж талбай, олон нийтийн газруудад эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчил гаргасан 2448 иргэнийг 77,654,500 төгрөгөөр торгож, захиргааны арга хэмжээ авч ажилласан.

Цагдаагийн хэлтсээс орон нутгийн хэмжээнд “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ”, залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Залилагчид боломж бүү олго” нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж байна.

Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирох, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Хичээл эхэллээ” арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд Уул, уурхайн жишиг сургууль Политехникийн коллежийн оюутнууд болон аймгийн хэмжээний Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад эрх зүйн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. мөн “Хүүхдийн эрх, хамгаалал, гэмт хэрэг, зөрчлийн талаарх ойлголт, урьдчилан сэргийлэх тухай” сэдвээр аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах бүлгийн 240 сурагчид мэдээлэл сургалт зохион байгуулсан.

Мэргэжлийн хяналтын газар: Улсын байцаагчийн хяналт шинжилгээ болон иргэн, аж ахуй нэгжийн хүсэлтээр 354 сорьцонд 890 үзүүлэлтээр хими, нян судлалын хорио цээрийн шинжилгээг гүйцэтгэн хяналт тавьж, хариуг баталгаажуулсан. Шаардлага хангаагүй 12 сорьц илэрч, холбогдох улсын байцаагч нарт хариуг хүргүүлсэн.

Онцгой байдлын газар:

Аймгийн хэмжээнд гал түймрийн объектын дуудлага 1, галт зэвсгийн дуудлага 1 удаа бүртгэгдсэн.

Монгол Улсын Шадар Сайдын баталсан Уул уурхай баяжуулах үйлдвэр, Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжид гамшгаас хамгаалах чиглэлээр төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 25-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг зохион байгуулж 4 байгууллагын 61 ажилтан, албан хаагчийг хамруулж, үер, усны осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх мэдлэг ойлголт өгч, гал унтраах дадлага сургууль хийсэн.

Үер усны осолоос урьдчилан сэргийлэх “АНХААРХАД Л БОЛНО” аяны хүрээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллагын 101 ажилтан, албан хаагчдад 8 удаагийн сургалт зохион байгуулсан.

Онцгой байдлын ерөнхий газар болон Цаг, уур орчин шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ 2, Онцгой байдлын газрын үйл ажиллагааны чиглэлээр 25 мэдээ нийт 227 мэдээг цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулан иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэсэн бөгөөд go.nema.gov.mn сайтад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 49055 хандалт хийгдсэн байна.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн “Багш нарын бага хурал”-ыг зохион байгуулсан.

Бага боловсролын Монголхэл, математикийн хичээлийн суурь чадварын судалгааг зохион байгууллаа. Судалгаанд ерөнхий боловсролын 5 сургуулийн 2-5 дугаар ангийн 57 бүлгийн 1690 сурагчид хамрагдсан.

Багш нарын мэргэжил арга зүйг дээшлүүлэх, туршлага судлуулах зорилгоор Монгол хэл, Англи хэлний багш нарын холбооноос жил бүр зохион байгуулдаг Олон Улсын конференсэд аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 15 багш оролцлоо. .

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр: “Залуусын оролцоо-хөдөлмөр эрхлэлт-2022” залуучуудын хөгжлийн сарын аяны хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл өсвөр насны хүүхэд, залууст чиглэсэн сургалт, хөдөөгийн малчин залууст зориулсан явуулын үйлчилгээ, зорилтот өрхүүдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлуудыг аймгийн хэмжээнд зохион байгуулж байна.

Иргэд, хүүхэд, залуучуудад эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамирыг сурталчилан таниулж, иргэдийг хөдөлгөөний дутагдалд орохоос урьдчилан сэргийлэх, зөв дадалтай болгох, байгууллагын дэргэдэх спорт хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Биеийн тамир, спортын газар, “XS” бялдаржуулах клубтэй хамтран 2022 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр “Хөдөлгөөн эрүүл мэнд” арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн нийт 25 байгууллагын 200 гаруй албан хаагч, иргэд, хүүхэд залуус хамрагдсан.

“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх, нийгэмд тулгамдаж буй хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд залуучуудын дуу хоолой, үзэл бодол, бүтээлч санаачилга, шийдлийг дэмжиж, чадавхжуулах зорилготой “Next Gen-шинэ сэргэлт” үндэсний хэмжээний төслийн уралдаан 2022 оны 08 дугаар сарын 01-ны өдрөөс 12 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл явагдаж байна.

Соёл, урлагийн чиглэлээр: Соёлын яамны үзэсгэлэнгийн танхимд “Тэгш таван хүсэл” Монгол бичгийн уран бичлэгийн үзэсгэлэнг Ерөнхий боловсролын 5-р сургуулийн Э.Олонцэцэг багштай “Эрдэнийн бийр” дугуйлангийн сурагчид оролцсон бөгөөд дугуйлангийн 10 сурагч Тэргүүний уншигч Нацагдорж тэмдэгтээр шагнагдсан.

Соёл, урлагийн ажилтны өдрийг жил бүрийн 9 дүгээр сарын 2 дахь ням гарагт тэмдэглэн өнгөрүүлэхээр Засгийн газраас шийдвэрлэсний дагуу “СОЁЛЫН ОРОН ЗАЙ” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Монголын бүх ард түмний спортын 15 дугаар наадамд тамирчид, багш, дасгалжуулагч нар оролцож, боксын төрөлд 1 мөнгө, 2 хүрэл медаль авч багийн дүнгээр 21 аймгаас 3 дугаар байр эзэлсэн. Мөн Самбо болон жүдо бөхийн төрөлд 1 алт, 1 мөнгө, 2 хүрэл медаль, Пара хөнгөн атлетикийн төрөлд зээрэнцэг шитэлтийн F-55 ангилалд 1 алтан медаль тус тус хүртсэн амжилтыг үзүүлсэн.

Улс, бүсийн аварга шалгаруулах Жүдо, Жюү жицүгийн тэмцээнээс 1 алт, 2 мөнгө, 1 хүрэл медаль авсан амжилтыг үзүүлсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2021 оны 08 сар	2022 оны 08 сар
Төрсөн эх	351	262
Гэрийн төрөлт	3	2
Амьд төрсөн хүүхэд	355	260
Амьгүй төрөлт	1	2
Нас баралт	64	63
Эмнэлгийн нас баралт	21	18
Хоног болоогүй нас баралт	6	7
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	2
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	1
Эмнэлгээс гарсан хүний тоо	4513	4306
Амбулаторийн үзлэг	74779	79910
Халдварт өвчин	2806	2514

Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар ургийн хяналтын монитор, инкубатор, сэхээн амьдруулах ширээ, автомат тарианы шахуурга, ургийн доплер аппарат зэрэг тоног төхөөрөмжийг төрөх эмэгтэйчүүдийн тасагт хүлээлгэн өгсөн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Ажил олгогч аж ахуй нэгж байгууллагаас 46 ажлын байрны захиалга хүлээн авч, 18 иргэнийг түр ажилын байранд зуучилсан.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг ажилгүй, ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй 7 иргэнд үзүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй төлбөрт өссөн дүнгээр 2520,0 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн.

Малжуулах арга хэмжээний хүрээнд 4 өрхийн 8 иргэн төсөл ирүүлсэн бөгөөд ажлын хэсгийн хурлын шийдвэрээр 2 өрхийг сонгон шалгаруулж, мал нийлүүлэх ажлыг зохион байгуулахаар малын үнийн санал хүлээн авах зарлалыг явуулж байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд 68 өрхийн 246 гишүүнд 4352.0 мянган төгрөгийг олгосон.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Аймгийн дүнгээр 2021 оны жилийн эцсээр 432196 толгой мал тоолуулж, 2022 оны хавар 153.9 мян.тол төл бойжуулсан. Төлийн орлого, зүй бус хорогдол, эдийн засгийн эргэлтэд оруулах, дотоод хэрэгцээ, хүнсэнд хэрэглэх малыг тооцоолж, хонин толгойд шилжүүлснээр 683,5 мян.тол мал өвөлжиж, хаваржихаар байна. Энэ жил эдийн засгийн эргэлтэд 133.2 мян.тол мал оруулахаар тооцсон.

Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд өмнөх оны үлдэгдэл өвс 152 тн, тэжээл 58 тн, Сүмбэр сумын аюулгүйн нөөцөд өнгөрсөн оны үлдэгдэл өвс 50 тн, тэжээл 11.1 тн байна.

Аймгийн хэмжээнд хадлангийн 6 салаа, 4 иргэн орон нутагт болон Дорнод, Хэнтий аймгийн зарим сумдад хадланд гарч 9-р сарын 15-ны байдлаар 86 тн өвс бэлтгэсэн мэдээтэй байна.

Намрын хянан баталгаажуулалтын ажил үргэлжилж байна. Өвөлжилтийн байдал, цаг агаарын аюулт үзэгдэл, малын тарга хүч зэргээс хамааран нийт бог малын хээлтэгчийн 80 хувийг хээлтүүлэгт оруулахаар тооцоход хуц-253, ухна-362 дутагдаж байна. Дутагдаж байгаа хээлтүүлэгчийг эрүүл бүсээс худалдан авах, шинээр бойжуулсан болон зохиомол хээлтүүлэг хийж нөхөхөөр төлөвлөн ажиллаж байна.

Бизнес эрхлэгчид, малчдын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, өргөжүүлэх зорилгоор “Говийн бүсийн түншлэл – 2022” үзэсгэлэн худалдааг 09 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Говийн бүсийн 2 аймаг, Дархан-Уул аймаг, орон нутгийн бизнес эрхлэгч 96 иргэн аж ахуй нэгж оролцож 83.1 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Хүнсний нөөц: Аймгийн дүнгээр мах 39 тн буюу 23, гурил 85.3 тн буюу 61, сүү 3.6 тн буюу 2, төрөл бүрийн будаа 15.9 тн буюу 23, төмс 9.1 тн буюу 5, хүнсний ногоо 10.3 тн буюу 3, элсэн чихэр 8.3 тн буюу 18, давс 6.1 тн буюу 22, савласан ус 25 тн буюу 1, өндөг 3 тн буюу 11, ургамлын тос 7.9 тн буюу 25 хоногийн нөөцтэй байна.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2021 оны 8-р сарын үнийн мэдээ: Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 500 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал: төмс 100 төгрөгөөр, сонгино 100-150 төгрөгөөр нэмэгдэж, үхрийн мах /цул, ястай/ 500 төгрөгөөр, хонины мах /цул, ястай/ 500 төгрөгөөр, адууны мах /ястай/ 250 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

Үнийн мэдээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан үзэхэд дотооддоо үйлдвэрлэж буй малын мах төрөл тус бүрээр 250-500 төгрөгөөр, Төмс, хүнсний ногоо 250-800 төгрөгөөр, Сүү 500

төгрөгөөр, Гурил 50-150 төгрөгөөр буурсан бол импортын бүтээгдэхүүн болох Элсэн чихэр 200 төгрөгөөр, Цагаан будаа 500-1000 төгрөгөөр, Ургамлын тос 1000-1500 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ, төг	Доод үнэ, төг	Өссөн, буурсан
1	Үхрийн мах	Ястай	11000	10000	500
		Цул	13000	12000	500
2	Хонины мах	Ястай	8000	7000	500
		Цул	11000	10000	500
3	Адууны мах	Ястай	8500	8200	250
		Цул	8500	8000	
4	Ямааны мах	Ястай	7500	7400	
		цул	10000	10000	
5	Тахианы мах	Гуя	12000	10500	
		мөч	14300	11000	
6	Лууван	монгол	3300	3000	
		хятад			
7	Төмс	монгол	1200	1000	200
		хятад			
8	Байцаа	монгол	1500	1600	
		хятад			
9	Чинжүү	монгол			
		хятад	5000	8500	
10	Манжин	монгол	1500	1400	
		хятад			
11	Сонгино бөөрөнхий	Монгол	3500	3200	250
		Хятад			
12	Помидор	монгол	6500	6000	
13	Өргөст хэмх	монгол	6500	6000	
14	Элсэн чихэр	монгол	3300	2900	
15	Будаа	Цагаан задгай кг	4000	3000	
		Шар слава кг	5100	3000	
		Гурвалжин будаа кг	6000	4000	
16	Сүү	Задгай	3000	2800	
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	4300	4000	
17	Тараг	Задгай	3500	3000	
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	5500	3800	
18	Талх	Чойр талх	1650	1500	
19	Өндөг	ОХУ	400	330	
		Монгол	450	400	
20	Алтан тарианы гурил	Задгай дээд	1500	1300	
		Задгай 1-р зэрэг	1560	1400	
		Задгай 2-р зэрэг	1400	1000	
		Савласан д/дээд /	2400	2400	
		Савласан дээд	2200	1800	
		Савласан 1-р зэрэг	1600	1400	
		Савласан 2-р зэрэг	1200	1000	
21	Ургамлын тос	Олейна	10000	9500	

		Алтан	8000	7500	
22	Гоймон	Алейка	2800	2000	
		А/тариа савхан	1800	1000	

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: “Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 сарын 31-ний өдрийн 09 дугаар албан даалгаврын дагуу аймгийн хэмжээнд усны сан бүхий газруудын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 09 сарын 08-09-ний өдрүүдэд зохион байгууллаа. “Монгол орноо хогноос салгая” аяны арга хэмжээнд 6 байгууллагын 37 албан хаагч, 5 уст цэгийг хамруулж, 4.1 га талбайн 16 тн хог хаягдлыг цэвэрлэлээ.

Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, “Зөв дадал, эерэг өөрчлөлт, ногоон ирээдүй” аяны хүрээнд Шивээговь сумын 6 байгууллагын 134 иргэнд хог хаягдлаа багасгах, ангилан ялгах мэдлэг ойлголтыг өгч эерэг дадал хэвшлийг бий болгоход уриалж, хөрс бохирдуулахгүй, байгальд ээлтэй, шинэлэг технологи бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан мэдээлэл өгсөн.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Бэлчээрийн газрын хяналтын цэгт газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны хээрийн ажлыг “Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газар”-тай хамтран хийж гүйцэтгэлээ. Үүнд: Сүмбэр суманд 3 цэгт, Шивээговь суманд 3 цэгт, Баянтал суманд 3 цэгт нийт 9 цэгийн бэлчээрийн газарт хяналт хийж, даац тодорхойлох хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар барилга захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа он дамжин хэрэгжиж байгаа болон шинээр эхэлсэн 25,241,135,250 төгрөгийн гэрээний үнийн дүнтэй нийт 29 ажлын 9 ажил бүрэн дууссан байна. Үлдсэн 20 ажлын гүйцэтгэл 62,2 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагааны талаар: Төсвийн ерөнхийлөн захирагчид 2022 онд нийт 15,815,162.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 49 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна. Үүнээс 48 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан байна. Худалдан авах ажиллагааны явц 97.9 хувьтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 5 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 4 ажил, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 25 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 24 ажил, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 16 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 15 ажил, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар нийт 2 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2 ажлын тендер шалгаруулалтыг, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар нийт 1 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 1 ажлын тендер шалгаруулалтыг тус тус цахимаар зохион байгуулаад байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4 дэх заалт, Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 9 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн өмчтэй 43 хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийг нүд үзэж тоолох ажлыг зохион байгуулсан.

ДОЛОО. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум: Сумын хэмжээнд 4 цэгт үүссэн ил задгай хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 5 удаа зохион байгуулж 15 тонн хог хаягдал зайлуулсан.

2022.09 дүгээр сарын 10-ны өдөр малчдын зөвөлгөөн зохион байгуулж, төрөөс баримталж буй бодлого, орон нутгийн удирдлагаас зохион байгуулж буй ажил, хөдөө аж ахуй, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас мэдээлэл хийсэн. Тус арга хэмжээнд 38 өрхийн оролцсон.

Шивээговь сум: Төрийн байгууллагуудын үйлчилгээг иргэдэд нээлттэй, хүртээмжтэй бөгөөд ойроос хүргэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд сурталчлан таниулах, төрийн

үйлчилгээг нэг дороос хүргэх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан.

Сүмбэр сум: Өвөлжөлтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор сумын Засаг даргын А/171 дугаар захирамж, албан даалгавар гарган “СҮМБЭРИЙН МЭДЭЭ” цахим хуудас болон гарын авлага тараах материалаар хөдөөгийн багийн 126 малчинд хүргүүлсэн бөгөөд 2022-2023 өвөл, хавар сумын нутаг дэвсгэрт 6 багийн 327701 толгой мал өвөлжиж 8 хаваржих тооцоо гарсан.

Мал эмнэлгийн лаборатори тандалт шинжилгээний ажлаар хөдөөгийн багуудад ажиллаж, цусан халдвартаас сэргийлэх вакцинжуулалтад 9 өрхийн 8356 толгой мал хамруулж, дотрын халдварт хордлогоос сэргийлэх вакцинжуулалтад 30 өрхийн 45832 толгой мал хамруулаад байна.

Сумын Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/175 дугаар захирамжийн дагуу золбин нохой, муур устгах ажлыг “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ 09 дүгээр сарын 05-09-ний өдөр хүртэл 5 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ. Сумын төвийн 3 баг, хөдөөгийн 4, 5-р багт зохион байгуулж 359 золбин нохой, 73 муурыг 8,640,000 төгрөгөөр устгаж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж, ариутгал хийж ажилласан.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР